



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/98

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 7.1, 9.4 дэх заалт, Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг нэгдүгээр, дахин хэлэлцэж магадлан итгэмжлэлийн хугацааг өөрчлөх эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, батламжийг олгосугай.

2. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн гуравдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141260384

Эрүүл мэндийн сайдын
2026 оны 03 сарын 03-ны өдрийн
0178 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Чингэлтэй нэгдсэн эмнэлэг	14/2026	2 жил	2026.02.27	2028.02.27
2.	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Цу Эрдэнэ ХХК-ийн эмнэлэг	15/2026	3 жил	2026.03.02	2029.03.02
3.	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Экспресс лаборатори ХХК-ийн эмнэлэг	16/2026	2 жил	2026.02.28	2028.02.28